



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2020 оны 05 сарын 19 өдөр

Дугаар 279

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1, 5.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Монголросцветмет” төрийн өмчит үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй хавсралтад заасан нийт 79,000,000.00 (далан есөн сая) төгрөгийн балансын үнэ, 7,899,998.40 (долоон сая найман зуун ерэн есөн мянга есөн зуун ерэн найман төгрөг дөчин мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий автомашиныг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт балансаас балансад шилжүүлсүгэй.

2. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Дэд дарга А.Дагвадорж “Монголросцветмет” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал Б.Мөнхбат нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Автомашины улсын дугаарыг бүртгэлээс шилжүүлсэн тодорхойлолт арга хэмжээний биелэлтийг 2020 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

З.МЭНДСАЙХАН

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Д.НАРАНГЭРЭЛ

300400



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2020 оны 05 дугаар сарын 19 өдрийн
279 дугаар тогтоолын хавсралт

**"МОНГОЛПРОСЦЕВМЕТ" ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ
ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАРТ БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ АВТОМАШИН**

д/д	Хөрөнгийн нэр	Үйлдвэрлэсэн /ашиглалтад орсон огноо	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)
1	Хьюндай Соната LF маркийн, ,8759 УБХ арал KNMECBKA510777	2018/2019	ш	1	79,000,000.00	7,899,998.40	71,100,001.60
					79,000,000.00	7,899,998.40	71,100,001.60
	Нийт дүн				(далан есөн сая)	(долоон сая найман зуун ерэн есөн мянга есөн зуун ерэн найман төгрөг дөчин мөнгө)	(далан нэгэн сая нэг зуун мянга нэг төгрөг жаран мөнгө)